



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 4/70

Чойбалсан

Г

“Байгаль шинжлэл-2025”
төсөл хэрэгжүүлэх тухай”

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.3, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 3 дугаар хуралдааны 03/04 тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 1.1.1, тус хуралдааны 03/04 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдын дунд байгаль, шинжлэх ухааныг судлах, танин мэдэх, суралцах чадварыг хөгжүүлэх, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 28,000,000 (хорин найман сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.12 дахь заалт “Байгалийн шинжлэх ухааныг судлах, танин мэдэх суралцах чадварыг хөгжүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-тай байгуулах “Орон нутгийн хөгжлийн сан”-аас дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Н.Нарангэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус даалгасугай.

4.Арга хэмжээг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЕЛ



2125010159

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дүгээр сарын 25-ны өдрийн
А/72 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

“БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ-2025” ТӨСЛИЙН УДИРДАМЖ

Үндэслэл:

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, боловсролын үйлчилгээ олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй байх, багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах, багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоо бүрдүүлэх тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх, “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)”-д багш мэргэжилтний тасралтгүй хөгжлийг боловсролын чанарыг сайжруулах тулгуур зорилт болгох асуудлыг тус тус тусгасан.

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил, байгаль орчинд гарч буй өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн хувьсал, хөгжлийн онцлогоос үл шалтгаалан суралцагч нь шинжлэх ухааны мэдлэг, танин мэдэхүй, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвартай, сониуч, өөрийн суралцахуйг удирддаг, бусдын санал үнэт зүйлд хүндэтгэлтэй ханддаг, өсөлтийн сэтгэлгээтэй байх шаардлагатай болж байна. Иймээс багш нар өөрсдөө мэргэжлийн мэдлэг ур чадвартай байхаас гадна сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад гарах үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг, сурагч төвтөй суралцахуйг дэмжсэн арга зүйн чадамжтай, тасралтгүй хөгжих хандлагатай, мэдээлэл технологийн ур чадвартай, бусадтай хамтран насан туршдаа суралцаж чаддаг байх хэрэгтэй юм.

Дорнод аймгийн хувьд байгалийн шинжлэх ухааны хичээлүүдийн аймгийн сурлагын амжилт, чанар улсын дундажтай харьцуулахад дээгүүр байгаа хэдий ч чанарын үзүүлэлтээр хангалтгүй байгаа тул суралцагчдын шинжлэх ухаан, танин мэдэхүйн чадварыг ахиулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Иймд Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлэх, сонирхолд нь тулгуурлан хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх замаар шинжлэх ухаанч хандлагатай, техник сэтгэлгээтэй бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ-2025” төслийг хэрэгжүүлнэ.

Зорилго:

Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлэх, сонирхолд нь тулгуурлан хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх замаар шинжлэх ухаанч хандлагатай, техник сэтгэлгээтэй бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилготой.

Зорилт:

1. Суралцагчдын шинжлэх ухаанч мэдлэг чадварыг нэмэгдүүлж, сурлагын амжилт чанарыг сайжруулах
2. Багш нарын ажлын гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
3. Байгалийн ухааны кабинетад дэмжлэг үзүүлэх

Хэрэгжих хугацаа: 2025 оны 01-12 дугаар сар

Хамрах хүрээ: Дорнод аймгийн ерөнхий боловсролын 26 сургуулийн IV-XI дүгээр анги болон байгалийн ухааны дугуйлангийн суралцагчид, байгалийн ухааны судлагдахууны багш нар

Шаардагдах төсөв: 28.0 сая төгрөг

Санхүүжилтийн эх үүсвэр: Орон нутгийн төсөв

Үйл ажиллагааны чиглэл:

- “Байгаль шинжлэл-2025” аян зохион байгуулах
- “Шинэ санаа-Шилдэг арга зүй” арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, бүтээлийн үзэсгэлэнг жил бүр аймгийн хэмжээнд сурталчлах
- Байгалийн ухааны кабинет шинээр байгуулах, тохижуулахад дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн:

- Хүүхдийн авьяас, ур чадварыг хөгжүүлэх дугуйлан клубын нэр төрлийг нэмэгдүүлснээр бүх түвшинд хүүхдийн оролцоо нэмэгдэж, хүртээмж сайжирч, тэгш нөхцлөөр хангагдсан байна.
- Багш нарын онол арга зүйд ахиц гарсан байна.
- Байгалийн ухааны хичээлийн сургалтын орчин, сургалтын хэрэглэгдхүүний хүртээмж, кабинетаар хичээллэх боломж нэмэгдэнэ.

---oOo---

Аймгийн Засаг даргын 2025 оны
0.2 дүгээр сарын 0.5-ны өдрийн
4/20 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

“БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ-2025” ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шаардагдах төсөв
1	“Байгаль шинжлэл-2025” тайлант өдөрлөг зохион байгуулах	4.0 сая
2	Суралцагчдын ахиц амжилтын судалгааг тогтмол зохион байгуулах замаар сурагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах	3.0 сая
3	Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах	2.0 сая
4	“Шинэ санаа-Шидэг арга зүй” арга хэмжээ зохион байгуулах	1.0 сая
5	Байгалийн ухааны кабинетад дэмжлэг үзүүлэх	18.0 сая
	НИЙТ	28.0 сая

---oOo---